

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2023 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2023.03.15 № 99

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН ХОТ
БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА
ОНӨААТҮГ-ИЙН ЗАХИРАЛ
Ц.БАЯРЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын биет бус хөрөнгийн дансанд 607,387.3 мянган төгрөгийн өртөг бүхий 10 зураг байгаагаас 8 ажлын гүйцэтгэл дууссан, хүлээлгэж өгсөн ч данснаас хасалт хийгээгүй байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 5 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Үүнээс томоохон хийгдсэн ажлыг дурдвал " Хот дахин төлөвлөн барилгажуулах, дэд бүтэцжүүлэх төслүүд" Улсын анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулсан байна.

2022 оны Бизнесийн төлөвлөгөөнд тусган 16 ажилтантай байсныг нэмэгдүүлж, " Хот дахин төлөвлөлтийн орон сууцны хэсэг " нэмэгдэн 27 ажилтантай

Бусад асуудлын хэсэг

Өөрийн орлогоор санхүүждэг байгууллага ба 2022 онд 736,3652.2 мянган төгрөгийн орлоготой ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	52,538,500.00	110,058,098.98
1.1.2	Дансны авлага	23,000,000.00	429,000.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	313,300.00	27,025,177.78
1.1.4	Бусад авлага	-	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	13,710,300.00	7,152,586.20
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	89,562,100.00	144,664,862.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	928,830,500.00	1,016,916,599.00
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	928,830,500.00	1,016,916,599.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,018,392,600.00	1,161,581,461.96
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	БОГИНО ХУГААЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	-	-
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	10,701,700.00	14,116,963.71
2.1.1.4	НДШ - ийн өглөг	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,701,700.00	14,116,963.71
2.2	Өр төлбөрийн нийт дүн	10,701,700.00	14,116,963.71
2.3	Эздийн өмч		
2.3.1	төрийн	830,830,800.00	904,990,800.00
2.3.2	Дахин үнэлгээний нэмэгдэл	955,500.00	955,500.00
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	175,904,600.00	241,518,198.25
2.3.12.	Эздийн өмчийн дүн	1,007,690,900.00	1,147,464,498.25
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,018,392,600.00	1,161,581,461.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	736,362,255.50
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-
3	Нийт ашиг (алдагдал)	736,362,255.50

4	Түрээсийн орлого	-
5	Хүүний орлого	-
6	Ногдол ашгийн орлого	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-
8	Бусад орлого	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	663,439,924.50
11	Санхүүгийн зардал	-
12	Бусад зардал	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-
17	Бусад ашиг (алдагдал)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	72,922,331.00
19	Орлогын татварын зардал	7,292,233.10
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	65,630,097.90
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	65,630,097.90
23	Бусад дэлгэрэнгүй орлого	
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	
23.3	Бусад олз (гарз)	
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	65,630,097.90
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	Мөнгөн орлогын дүн	832,908,187.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	809,472,586.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	23,435,601.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	803,987,943.17
1.2.1	Ажиллагчдад төлсөн	320,215,287.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	96,751,856.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	98,953,483.80
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	29,509,381.92
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,367,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	97,242,672.14
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	420,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	143,528,261.17
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	28,920,243.83
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	Мөнгөн орлогын дүн	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	41,267,499.00

2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	41,267,499.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(41,267,499.00)
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(12,347,255.17)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	52,538,500.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	110,058,098.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мерийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	955,500.00	830,830,800.00	175,904,600.00	1,007,690,900.00
3	Залруулсан үлдэгдэл	955,500.00	830,830,800.00	175,904,600.00	1,007,690,900.00
9	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	955,500.00	-	175,904,600.00	176,860,100.00
11	Залруулсан үлдэгдэл	955,500.00	830,830,800.00	175,904,600.00	1,007,690,900.00
13	Бусад дэлгэрэнгүй орлого		74,160,000.00	65,630,097.90	139,790,097.90
17	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	955,500.00	830,830,800.00	175,904,600.00	1,147,480,997.90

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 584.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 584.0 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагналаа.

Үүнд: Тусгай зориулалтын материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байсныг залруулав.

Аудитаар нийт 2,464.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 2,223.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, материаллаг бус 1 албан шаардлага хүргүүлж, 240.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогч 9 сард ажилд томилогдон ирцийн бүртгэлээр 5 хоног ажилласан боловч 14 хоног ажилласнаар тооцож 377,531 төгрөгийн цалин илүү тооцож авсан, ажлын үр дүнг тооцоогүй дараа оны 2 сард санхүүгийн тайлан гараагүй байхад 567,800 төгрөгийн үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42.1.3-т "Гүйцэтгэсэн ажил үүрэгтэй тохирсон цалин хөлс авах", Хөдөлмөрийн тухай хуулийн 107.1-д "Ажил олгогч хуульд өөрөөр заагаагүй бол үндсэн цалинг ажлын байрны шинжилгээ, үнэлгээ, эсхүл ажилтны ур чадварт үндэслэн цагаар, хийснээр, бусад хэлбэрээр тооцно" гэж заасныг зөрчсөн байна.

2. Томилолтын хуудас, томилолтоор ажилласан газрын баталгаажуулалт, ажлын тайлан байхгүй, томилолтын зардлын бодолт тооцоололгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 1,278,500 төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ нь

Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан “дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.2 Албан шаардлага

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд солигдсон боловч ажил хүлээлцэж тооллого тооцоо хийгээгүй, жилийн эцсийн бараа материалын тооллого хийгдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-д “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэг ажилтны цалинг бодож олгохдоо 474.5 мянган төгрөгөөр тооцож НД-ын тайланд 715.0 мянган төгрөгөөр буюу 240.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалт зөрчигдсэн байна.

Өгсөн зөвлөмж: Цалин, хөдөлмөрийн хөлс түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тайлагнах.

2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд барилга болон авто замын 10 зураг бүртгэлтэй байх ба биетээр тоолоход 8 зургийг хүлээлгэн өгсөн, үлдэгдэл 2 зураг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-д “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгө, бараа материалын тооллогыг үнэн зөв бодитойгоор явуулж баталгаажуулан, данс бүртгэлд тусгаж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тусгай зориулалтын материалыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.	1	584.0					1	584.0				
Дүн	1	584.0					1	584.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тухайн байгууллагын нягтлан бодогч цалин илүү тооцож авсан, ажлын үр дүнг тооцоогүй, гаргаагүй байхад үр дүнгийн урамшуулал бодож олгосон байна.	1	945.3	1	945.3					-	-	-		
Томилолтын зардлыг тооцоходоо анхан баримт байхгүй байна.	1	1,278.5	1	1,278.5									
Тайлангийн хугацаанд байгууллагын нягтлан бодох бүртгэлийн ажилтнууд солигдсон боловч ажил хүлээлцэж тооллого тооцоо хийгээгүй, жилийн эцсийн бараа материалын тооллого хийгдээгүй байна.	1	-			1	-							
Ажилтны цалинг бодож олгоходоо НД-ын тайлан, цалингийн тооцооны хүснэгтээрх цалин зөрүүтэй тайлагнасан.	1	240.5						1	240.5				
Биет бус хөрөнгийн дансанд 10 зураг бүртгэлтэй байх ба биетээр тоолоход 2 зураг байна.	1	-						1	-				
Дүн	5	2,464.3	2	2,223.8	1	-	2	240.5					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилгүй.												

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			